


**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРЭЭНД 2021 ОНД АВЛИГА, ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**


2021.11.12


N	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх		
1	Хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилогдох албан тушаалтны Хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлгийг АТГ-ын Дүн шинжилгээний хэлтэст хянуулж, томилох.	2021 онд Хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянуулахаар албан тушаалтан томилогдоогүй байна.
2	Төрийн захиргааны болон үйлчилгээний удирдах, албан тушаалтнуудын хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч АТГ-т тайлан, нэрсийг хуулийн хугацаанд хүргүүлэх.	Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, бүртгэн хянаж хуулийн хугацаанд 1 албан хаагчын материалыг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэлийг дэвтэрт цаг тухайд нь хөтлөн ажиллаж, АТГ-ын ЭБАТ-ын эрхээр тайлангаа шивж хуулийн хугацаанд төв ЭБАТ-д бичмэл тайланг гаргаж хүргүүлэн ажилласан.
3	Албан тушаалын сул орон тооны ажлын байрны тавигдах шаардлагыг нээлттэй ил тод байдлыг ханган ажиллах.	Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг батлах тухай” 415, “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2020 оны А/37 дугаар тушаал болон Аймгийн Засаг даргын 2021 оны А/253 дугаар захирамжаар Эрүүл мэндийн газар нь: 1.Удирдлага төлөвлөлтийн хэлтэс 2.Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс 3.Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс 4.Нийгмийн эрүүл мэндийн төв гэсэн 4 хэлтэст 30 албан хаагч ажиллаж байна. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс болон Нийгмийн эрүүл мэндийн төвд төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын ТЗ-5 ангилал зэрэглэлд хамаарах 12 сул орон тооны ажлын байрны тавигдах шаардлагыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, мэдээллийг байгууллагын веб хуудсанд байршуулсан. Эрүүл мэндийн газрын “og.mohs.gov.mn” цахим хуудсанд “Хүний нөөцийн ил тод байдал”-ыг хангаж, албан тушаалын сул орон тооны мэдээллийг байршуулсан. Мөн Хөдөлдмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн цахим хуудас болон

	<p>Монгол улсын төрийн албаны зөвлөлийн “csc.gov.mn” цахим хуудсанд ЭМГ-ын сул орон тооны зар мэдээллийг тухай бүрт нь байршуулан, сул орон тоог нөхөж ажиллаж байна.</p>  <p>The screenshot shows the website interface with a blue header and a list of job openings under the heading 'СУЛ АЖЛЫН БАЙРНЫ ЗАР'. The list includes positions like 'Хүний нөөций ил тод байдал' and 'Төсөв санхүүгийн ил тод байдал'. A navigation menu on the right lists various services like 'Хүний нөөцийн гөлөвлөлт' and 'Шагнал урамшуулал'.</p>
--	---

<p>4</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил, өргөдөл, гомдлыг судалж тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p>	<p>ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо нь нийт 3 удаагийн хурлыг зохион байгуулж 6 асуудлыг хэлэлцэж 100 хувь шийдвэрлэсэн. ЭМЯ-ны дэргэдэх ёс зүйн хяналтын хороо болон бусад ТТБ-уудтай хамтран ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр нийт 34 сургалт зохион байгуулж 1191 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, 509 үйлчлүүлэгчийг хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо 787 нэмэгдүүлж ЭМГ-т ирсэн гомдол 3,5 дахин буурсан үзүүлэлттэй байна. ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд зөрчил өргөдөл гомдол бүртгэгдээгүй байна.</p> <p>Иргэдийн санал гомдлыг холбогдох эмч, эмнэлгийн ажилтанд танилцуулан</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхдийн тасгийн үйл ажиллагаатай холбоотой гомдол-3 ирсэн. БОЭТ-ийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн өвчтөнд тавих хяналтыг сайжруулах, тасгийн дотоод зохион байгуулалтыг өөрчилөх үүрэг өглөө • 2 өвчтний ар гэрт тус бүр 500,000 төгрөгийн нөхөн олговор олгуулсан. (Гэмтэл, Түргэн тусламжийн тасаг) • Үйлчлүүлэгчээс зүй бусаар мөнгө авсан үйлчлэгчээс 350,000 төгрөгийг буцаан олгуулсан • Дурангийн шинжилгээ хийлгэхэд 60,000 төг төлбөр авсан байсныг иргэнд буцаан өгсөн • 2021 оны 3 сарын 01-нээс ЭМД-ын сангаас ЭМБ-уудад гүйцэтгэлд
---	---

	<p>суурилсан санхүүжилт олгох болсон, өндөр өртөгтэй тусламж үйлчилгээний санхүүжилт олгохоор болсон тул эмч эмнэлгийн ажилчдад иргэдээс төлбөр нэхэх асуудлыг таслан зогсоохыг анхааруулсан.</p> <ul style="list-style-type: none"> • Эмчийн харьцаа хандлагатай холбоотой гомдол Амбулаторийн тасгийн 3 эмчид ирсэн. – эмч нартай үйлчлүүлэгчийг уулзуулан эвлэрүүлэн зуучилж 2 эмчийн 1 сарын үр дүнгийн урамшууллыг хасах арга хэмжээ авсан. • Шүдний эмчилгээнд сэтгэл ханамжгүй 1 тохиолдлыг өөр туршлагатай эмчээр үзүүлэн шийдвэрлэсэн. • Эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах 2 саналыг БОЭТ-ийн удирдлагад танилцуулан шийдвэрлэхээр болсон. (унтуулгатай дуран хийдэг болох, түргэн тусламжийг дуудлагын утсыг засварлах) • Коронавируст халдварын үед эмнэлгийн дотоод зохион байгуулалтг урсгал хөдөлгөөнийг сайжруулах санал хүсэлт 9 ирснийг тухай бүрт нь шийдвэрлэн ажиллалаа.
<p>5 Эрүүл мэндийн байгууллагуудын нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, авлига, ашиг сонирхлын зохицуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, салбарын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах.</p>	<p>Эрүүл байгууллагад нийт 7 шинээр орж ирсэн мэргэжилтнүүдийг АТГ-гаас 9-р сард зохион явуулсан цахим сургалтанд оролцон хуулийн мэдлэгтэй болсон.</p>
<p>Хоёр. Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд</p>	
<p>1 ЭМГ-ын сайтад Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайланг цахим хуудсанд байршуулж, иргэдийг мэдээллээр хангах боломж нөхцлийг бүрдүүлэх.</p>	<div data-bbox="1137 762 2060 1050" data-label="Image"> </div> <p>Эрүүл мэндийн газрын цахим хуудас or.mohs.gov.mn домайн хаягтайгаар ажилладаг. Тус цахим хуудасны “Ил тод байдал” цэсэнд “Авлигын эсрэг” цэсийг байршуулан, Эрүүл мэндийн газрын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний тайлан биелэлтүүдийг байршуулан ажиллаж байна. Мөн АТГ-аас 2021 оны 10-р сард ЭМБ-дад шинээр орсон албан хаагч нарт цахим сургалтыг зохион байгуулж нийт 20 гаруй эрүүл мэндийн албан хаагч нар оролцсон.</p>
<p>2 Өргөдөл гомдлыг программаар заавал бүртгэх, өргөдөл, гомдлын утга агуулгыг ангилж бүртгэх, мөн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг оруулж хэвших.</p>	<p>Тайлант хугацаанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой 62 хүсэлт, 2 гомдол бүртгэгдсэн иргэдийн санал, гомдол, хүсэлтийг хугацаанд нь холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд 100% шийдвэрлэсэн. Өргөдөл,</p>

	гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл Аймгийн ЗДТГ-ын шуурхай хурал, erdenet.mn, 70353511 дугаарт утсанд бүртгэгдэж, эргэн иргэдэд мэдээлэгдэж байгаа нь иргэдийн талархлыг хүлээсэн.
3 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, хандив, зээл тусламжийн ил тод байдлыг хангаж ажиллах.	<p>“Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтийг хангах үүднээс байгууллагын нэгдсэн цахим хуудсанд сар бүр, улирал бүр, Хагас жил, жилийн эцэст тавигдах мэдээ мэдээлэл, төсвийн гүйцэтгэлийн ил тод мэдээ мэдээлэл, зээл, хандив, тусламжийн орлого, зарцуулалтын тайлан зэргийг хуулинд заасан хугацаанд багтаан байршуулж, сар, улирал бүр Төсвийн ерөнхийлөн захирагчид сар, улирлын тайланг хүргүүлэн ажиллаж байна. 2021 оны 10 сарын тайлан болон III улирлын тайланг 10-р сарын 10-ны дотор Эрүүл мэндийн яам болон Сангийн яаманд тайланг хүргүүлсэн.</p> <p>Мөн цахим хуудас or.mohs.gov.mn домайн хаягтайгаар ажилладаг бөгөөд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, “Шилэн данс” товч, “ил тод байдал” цэсийг байршуулсан. Үүнд “Төсөв санхүүгийн ил тод байдал” цэсэнд санхүүгийн үйл ажиллагааны холбогдох мэдээллүүдийг тогтмол оруулж байна.</p> <p>Цахим хуудсанд тус цэсэнд эрүүл хандивын мэдээллийг тухай  “Хандив тусламж” цэсийг оруулан, мэндийг газарт ирүүлсэн хандив, зарцуулалт хувиарлалтын бүр оруулж байна.</p>
Гурав. Хяналт хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх	
1 Тендерийн үнэлгээний хороонд ажиллаж байгаа ажилтнуудын ашиг сонихлын зөрчилгүйг илэрхийлэх мэдэгдлийг тогтмол авч хэвших.	2021 онд Тендерийн ажлыг зохион байгуулаагүй.
2 Төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийн орлого түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг мэдээлэх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх.	“Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтийг хангах үүднээс байгууллагын нэгдсэн цахим хуудсанд сар бүр, улирал бүр, Хагас жил, жилийн эцэст тавигдах мэдээ мэдээлэл, тайлан, төсвийн орлого, зарлага, хандив тусламжийн орлого, зарцуулалт, төсвийн хуваарилалт зэргийг хуулинд заасан хугацаанд багтаан байршуулж, сар, улирал тус бүр байршуулан ажилласан. Эрүүл мэндийн газрын “or.mohs.gov.mn” цахим хуудсанд Шилэн данс, төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийн орлого, түүний зарцуулалт, хандив

	<p>тусламж, түүний хувиарлалтын мэдээллийг ил тод байршуулан ажиллаж байна.</p> 
<p>3 Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг идэвхижүүлэх, хяналт шалгалтын ажлыг төлөвлөх, дүнг мэдээлэх, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээг авч ажиллах.</p>	<p>Байгууллагын Дотоод хяналтын багийн 2021 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажилласан Дотоод хяналтын багаас 2020 оны хяналтын дүнгүүдийг үндэслэн албан хаагчдад зөвлөмжийг И-оффисын дотоод мэйлээр хүргүүлэн 2021 оны төлөвлөлтөд тусган ажиллуулсан.. Тайлант хугцаанд Дотоод хяналтын баг 2 удаа хуралдаж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт хийгдэж байгаа байдлыг хэлэлцэн гишүүдийг үүрэгжүүлж, хяналтын дүгнэлт, зөвлөмж дээр санал солилцон, шийдвэрийг гарган ажилласан. Төлөвлөгөөний дагуу нийт төлөвлөгөөт 7 төлөвлөгөөт бус 3 хяналтыг хийсэн. Удирдлагын зөвлөлийн хурлаар 4 хяналтын дүнг хэлэлцэж, үүрэг даалгавар өгөгдсөн. Албан хаагчдад тухай бүр цахимаар дотоод хяналт хийгдсэн тухай илтгэх хуудас, зөвлөмж хүргүүлэн ажилласан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээ” сертификат бүхий цахим сургалтад ЭМГ-ын 11 албан хаагчийг идэвхжүүлэн хамруулсан. 2020-2021 онд батлагдсан хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг ЭМГ-ын цахим хуудаст байршуулан сурталчилсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 87%-тай байна.</p>

ХЯНАСАН:ЭМГЫН ДАРГА

Д.СҮХЭЭ

БОЛОВСРУУЛСАН: ЭДИЙН ЗАСАГЧ, ЭБАТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ОТГОНДЭЛГЭР